| 2.12 | Хэлтсийн албан хэрэг хөтлөлтийг, баримт бичгийн стандартын дагуу хөтлөх | - | -Баримт бичгийн эргэлтийн тоо;<br>-Хугацаатай хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн хувь; | 2021 оны жилийн эцсийн байдлаар тус хэлтэст нийт 781 бичиг ирсэн, үүнээс хариутай албан бичиг 550 байсан. Хариутай албан бичгийг шийдвэрлэлтийн байдал 100 хувьтай. | -Хэлтсийн албан хэрэг хөтлөлт стандартын дагуу хөтлөгдсөн байна. |  | Хэлтсийн хэмжээнд тайлант хугацаанд 1429 албан бичиг хүлээн авснаас 988 хариутай албан бичгийн хариуг холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллаж, 1344 албан бичгийг гарган нийт бичиг хэргийн эргэлт 2763 болсон байна. Тус хэлтэст бусад байгууллагаас ирүүлсэн албан бичгийн 69% нь хугацаатай албан бичиг байсан бөгөөд бүх хариуг хуулийн хугацаанд хүргүүлсэн болно.<br><br>-Мөн хэлтсийн даргын 34 тушаал гарснаас А тушаал 12, Б тушаал 22 тус тус гарсан байна.<br><br>-ABLE программд нийт дотоод албан бичиг 75 ирсэн ба 180 албан бичиг явуулсан байна. <a href="mailto:Khuvsgul@burtgel.gov.mn">Khuvsgul@burtgel.gov.mn</a> хаягаар 599 албан бичиг ирсэн ба 522 албан бичиг явуулсан бол орон нутгийн <a href="mailto:uburtgel@khs.gov.mn">uburtgel@khs.gov.mn</a> хаягаар 115 албан бичиг ирсэн, 72 албан бичиг тус тус явуулсан байна.<br><br>-Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын хэмжээнд тоон гарын үсэг ашиглаж эхэлсэнтэй холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэх албан бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулан Able програмаар | 100% |

|   |  |   |   |   |  |  |   |      |
|---|--|---|---|---|--|--|---|------|
|   |  |   |   |   |  |  | хүргүүлж, бичиг хэргийн зардал болон шуудангийн зардлыг хэмнэн ажиллаж хэвшсэн байна.   |      |
| <b>Зорилт 3.Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.</b> |  |   |   |   |  |  |   |      |
| 3.1   | Хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, батлуулж, хэрэгжүүлэн ажиллах | - | -Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу байцаагчийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон өдөр тутмын түүвэрчилсэн хяналтаар иргэний бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж иргэний улсын бүртгэлийн нийт 4171 бүртгэлд хяналт тавьж ажилласан. | Хяналт шалгалтын чиглэлээр 2022 онд хэрэгжүүлэн ажиллах 5 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд 357 бүртгэлд түүвэрчилсэн хяналт тавьснаас иргэний бүртгэлийн чиглэлээр 174, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 81, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 52, архивын чиглэлээр 50 бүртгэлийг шалгасан байна. Хяналт тавьсан бүртгэлээс нийт 148 зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилган ажиллалаа. Мөн хяналтын улсын байцаагчийн нийт 69 дүгнэлт гаргасан ба үүнээс хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 4, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 25, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 40 дүгнэлтийг тус тус гаргасан байна. |  | -Хяналт шалгалтын чиглэлээр 2022 онд хэрэгжүүлэн ажиллах 5 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжүүлэн ажилласан бөгөөд төлөвлөгөөний биелэлт 100% хангагдсан байна. Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд улсын алхах бүртгэгч, улсын бүртгэгч, улсын бүртгэлийн байгууллагын бусад ажилтан холбогдох эх нотлох баримт бичиг, жагсаалтыг гаргаж өгөх, хяналт шалгалтын үйл ажиллагаанд ач холбогдол бүхий программ хангамж, техник, технологийн асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд тухайн бүртгэлийн талаар нэмэлт мэдээлэл, тайлбар өгөх зэргээр хамтран ажиллалаа.<br><br>-Тайлант хугацаанд 2352 бүртгэлд түүвэрчилсэн хяналт тавьснаас иргэний бүртгэлийн чиглэлээр 1643, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 367, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 122, архивын чиглэлээр 220 бүртгэлийг шалгасан.<br><br>- Хяналт тавьсан бүртгэлээс нийт 196 зөрчлийг илрүүлж, зөрчлийг | 100% |

|     |  |   |   |  |  |  |  |      |
|-----|--|---|---|--|--|--|--|------|
|     |  |   |   |  |  |  | арилган ажиллалаа. Мөн хяналтын улсын байцаагчийн нийт 125 дүгнэлт гаргасан ба үүнээс хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 4, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 52, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 69 дүгнэлтийг тус тус гаргасан байна.  |      |
| 3.2 | Хэлтсийн болон даргын зөвлөлийн хурал, шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах      | - | -Хэлтсийн болон даргын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьсан байна.                             | Хэлтсийн болон даргын зөвлөлийн хурлаас өгсөн 7 үүрэг даалгаврын хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.      | 2022 оны хагас жилийн өдрийн байдлаар хэлтсийн 9 хурал, даргын зөвлөлийн 11 хурал тус тус болсон бөгөөд хурлын тэмдэглэлийг хөтлөн албажуулж, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.  |  | -2022 оны жилийн эцсийн байдлаар хэлтсийн 16 хурал, даргын зөвлөлийн 18 хурал тус тус болсон бөгөөд хурлын тэмдэглэлийг хөтлөн албажуулж, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>-Мөн Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хэлтсийн албан хаагчдад тухай бүрт танилцуулан, биелэлтийг хугацаанд нь УБЕГ-т хүргүүлэн ажилласан. | 100% |
| 3.3 | Хэлтсийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан, гүйцэтгэлийн тайланг заасан хугацаанд нь тайлагнах | - | Хэлтсийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан, гүйцэтгэлийн тайланг заасан хугацаанд нь тайлагнасан байна. | Хэлтсийн 2021 оны төлөвлөгөөг боловсруулан, батлуулж тайланг хагас, бүтэн жилээр гарган УБЕГ-т хүргүүлсэн. | Хэлтсийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 30 арга хэмжээтэйгээр боловсруулан, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар батлуулан, эхний хагас жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 28 арга хэмжээг хяналтандаа авч, мөн нэмэлтээр 1 ажлыг төлөвлөн хэрэгжилтийг 100% ханган ажиллаж |  | Хэлтсийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 30 арга хэмжээтэйгээр боловсруулан, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар батлуулан, төлөвлөсөн 30 арга хэмжээг хяналтандаа авч, мөн нэмэлтээр 2 ажлыг төлөвлөн хэрэгжилтийг 100% ханган ажилласан байна.  | 100% |

|     |  |                                       |   |   |   |  |  |      |
|-----|--|---------------------------------------|---|---|---|--|--|------|
|     |  |                                       |   |   | байна.  |  |  |      |
| 3.4 | Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх   | -                                     | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хувь. | 2021 оны жилийн эцсийн байдлаар 149 мэдээлэл шилэн дансны мэдээлэл байршуулж, 11 мэдээлэл хоцроосон байна.  | Шилэн дансны хуулийг хэрэгжилтийг ханган 2022 оны эхний 5 сарын байдлаар 60 шилэн дансны мэдээлэл байршуулж, 2022 оны 1 дүгээр улирлын шилэн дансны тайланг 04 дүгээр сарын 05-ны өдөр хуулийн хугацаанд нь илгээсэн.   |  | Тайлант хугацаанд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 100% ханган ажиллаж 2022 оны 11 сарын байдлаар шилэн дансны 133 мэдээлэл байршуулж, 2022 оны 3 дугаар улирлын шилэн дансны тайланг 11 дүгээр сарын 05-ны өдөр хуулийн хугацаанд нь илгээсэн.   | 100% |
| 3.5 | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах, тайлагнах, байршуулах. | Урсгал төсөв /682.4 32.5 сая төгрөг / | Тайлагнаж, байршуулсан мэдээллийн тоо.  | 2021 онд батлагдсан төсвөөр эхний 11 сарын байдлаар 623 020 300 төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 270 515 568 төгрөгийг оруулж улсын төсөвт төвлөрүүлээд байна. | -Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах үүднээс 2022 оны батлагдсан төсвийн хуваарийг Ил тод байдлын самбарт байршуулсан. Мөн төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаанд нь Улсын бэртгэлийн ерөнхий газрын СААХэлтэст хүргүүлэн ажиллаж байна.<br>-2022 оны эхний 5 сарын байдлаар батлагдсан 290 979 200 төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 120 158 500 төгрөгийг оруулж улсын төсвийн орлого 120 хувийн биелэлттэй байна.<br>-УБЕГын даргын 2022 оны 4 дүгээр сарын 26-өдрийн 1/3665 албан бичгээр |  | -Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах үүднээс 2022 оны батлагдсан төсвийн хуваарийг Ил тод байдлын самбарт байршуулсан. Мөн төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаанд нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын СААХэлтэст хүргүүлэн ажиллаж байна.<br><br>-2022 оны 11 сарын байдлаар батлагдсан 617 646 800 төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 191 048 933 төгрөгийг оруулж улсын төсвийн орлого 76,4 хувийн биелэлттэй байна.<br><br>-УБЕГын даргын 2022 оны 04 дүгээр сарын 26-өдрийн 1/3665 албан бичгээр 2021 оны үйл ажиллагаанд тодорхойлогдсон эрсдэлийн үнэлгээг хүргүүлсэн.<br><br>-УБЕГын даргын 2022 оны 05 дугаар сарын 26-өдрийн 8/4645 төрийн хэмнэлтийн тухай хуулийн | 100% |

|     |  |   |  |                                 |  |  |  |      |
|-----|--|---|--|---------------------------------|--|--|--|------|
|     |  |   |  |                                 | 2021 оны үйл ажиллагаанд тодорхойлогдсон эрсдэлийн үнэлгээг хүргүүлсэн.<br>-УБЕГын даргын 2022 оны 5 дугаар сарын 26-өдрийн 8/4645 төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд зөвлөмжийг мөрдөн ажиллаж байна.  |  | хүрээнд зөвлөмжийг мөрдөн ажиллаж байна.   |      |
| 3.6 | Тамга, тэмдэг хэрэглэх эрх бүхий этгээдээс хураалгасан тамга, тэмдгийг төрийн архивт шилжүүлэн хадгалуулах | - | -Төрийн архивт шилжүүлсэн тамга тэмдгийн тоо |                                 | -Иргэн хуулийн этгээдийн тамга, тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журмын дагуу 290-н хуулийн этгээдийн болон хуулийн этгээдийн эрхгүй этгээдэд тэмдэг, баталгааны тэмдэгийн хяналтын дугаарыг олгож 2022 оны 11 сарын 25-ны байдлаар татан буугдсан, хэлбэр ашиглалтын шаардлага хангахгүй болон бусад шалтгаанаар хураагдсан 44 ширхэг хуулийн этгээдийн тамга тэмдэг, баталгааны тэмдгийг хадгалалт хамгаалалтын шаардлага хангасан сейф шүүгэнд хадгалж хуулийн хугацаанд нь устгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. |  | -2022 оны 11 сарын 25-ны байдлаар иргэн хуулийн этгээдийн тамга, тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журмын дагуу 298-н хуулийн этгээдийн болон хуулийн этгээдийн эрхгүй этгээдэд тэмдэг, баталгааны тэмдэгийн хяналтын дугаарыг олгож, шинээр хуулийн этгээдэд тамга тэмдэгний хяналтын дугаар олгосон 211, ашиглалтын шаардлага хангахгүй болсон дахин хяналтын дугаар авсан 41, татан буугдсан, хэлбэр ашиглалтын шаардлага хангахгүй болон бусад шалтгаанаар хураагдсан 46 ширхэг хуулийн этгээдийн тамга тэмдэг, баталгааны тэмдгийг хадгалалт хамгаалалтын шаардлага хангасан сейф шүүгэнд хадгалж хуулийн хугацаанд нь устгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | 100% |
| 3.7 | Зөрчлийн тухай хууль, Зөрчил   | - | Шалган шийдвэрлэс                            | 2021 оны жилийн эцсийн байдлаар | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хуульд  |  | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасан үйл ажиллагааг  |      |

|     |   |   |                                   |  |  |  |   |      |
|-----|---|---|-----------------------------------|--|--|--|---|------|
|     | шалган шийдвэрлэх хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх                            |   | эн зөрчлийн тоо;                  | иргэний үнэмлэхээ хаяж үрэгдүүлсэн 169 иргэнд торгуулийн хуудсаар 7.010.000 төгрөгийн торгууль ногдуулсан байна. | заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 1-р улиралд нийт 10 аж ахуй нэгжид зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 5.000.000 төгрөгийн торгууль ногдуулаад байна.   |  | хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд 221 иргэн, хуулийн этгээдэд торгууль оногдуулсан бөгөөд 9.240.000 төгрөгийн торгууль, шийтгэх хуудас бичиж Төрийн сангийн торгууль, хүү төвлөрүүлэх дансанд орлого оруулсан байна.<br><br>-Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн хэргийн материалыг аймгийн Прокурарын газарт тухай бүрт хүргүүлж, хянуулан ажиллаж байна.   | 100% |
| 3.8 | Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулан батлан, хэрэгжүүлж ажиллах | - | - Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | -  | Зөрчлөөс урьдчилан сэргийлэх 5 арга хэмжээ бүхий ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу сумдын улсын бүртгэгч нарт зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаагийн цахим сургалт зохион байгуулж, аливаа зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлэн ажиллаж байна. |  | -Зөрчлөөс урьдчилан сэргийлэх 5 арга хэмжээ бүхий ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжүүлэн ажиллаж 100% биелэлттэй байна.<br><br>-Төлөвлөгөөний дагуу сумдын улсын бүртгэгч нарт зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 удаагийн цахим сургалт, 1 удаагийн танхимын сургалт зохион байгуулж, аливаа зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлэн ажиллаж байна.<br><br>-Тус хэлтсийн даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2022 онд шинээр иргэний үнэмлэх авах 2005, 2006 онд төрсөн 16 нас хүрч байгаа 2200 иргэний мэдээллийг Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд ургийн овог, эцэг эхийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг зэргийг шалгаж зөрчилтэй тохиолдолд архиваас ХААТР-11 маягтыг татаж зөрчлийг | 100% |



|     |  |   |   |  |  |  |  |      |
|-----|--|---|---|--|--|--|--|------|
|     |  |   |   |  |  |  | арилгуулахаар УБЕГ-т хүргүүлж ажилласан. Үүнээс: Хурууны хээ давхардсан, нэрийн толинд нэр баталгаажуулаагүй, ургийн овгийн мэдээлэл зөрүүтэй-84, эцэг/эх/-ийн нэр, нэр зөрсөн зөрчилтэй-46, мэдээллийн санд хаяггүй-25 иргэний мэдээллийг УБЕГ-т хүргүүлэн зөрчлийг арилгуулж цахим үнэмлэхийг баталгаажууллаа. Зөрчлийг урьдчилан шалгасны үр дүнд 16 нас хүрсэн иргэн үнэмлэхээ захиалахаар ирэхэд мэдээллийн санд зөрчилтэй шалтгаанаар хугацаа алдах эрсдэлгүй болж, иргэд хуулийн хугацаандаа үнэмлэхээ авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.  |      |
| 3.9 | Хууль, шүүхийн байгууллага ар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох | - | - Хууль, шүүхийн байгууллага ар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааны тоо<br>-Шүүх хуралдаанд оролцсон тоо<br>- Шийдвэрлэгдсэн шийдвэрийн мэдээ | Хууль хяналт, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон ажилласан. | Хууль хяналт, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаан гараагүй тул итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцоогүй болно. |  | -Тус хэлтсийн хэмжээнд хууль хяналт, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа 1 маргаан байгаа болно.<br><br>-Уг маргаан нь Иргэн Л.Ганбатын 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр гаргасан “Гурил тэжээл” ХХК-ийн ТТБ-2580 дугаартай тэмдгийг хүчингүйд тооцох тухай захиргааны акт гаргах нэхэмжлэл бөгөөд тус хэлтсийн хуулийн этгээдийн улсын бүртгэгч Н.Азжаргалыг тус хэлтсийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1/1299 албан бичгээр итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсон. Одоогийн байдлаар шүүх хурал явагдаагүй байгаа бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 1/1329 албан бичгээр тайбар гаргасан болно. | 100% |

**Зорилт 4. Орон нутагтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.**

|     |   |   |                                      |  |  |   |      |
|-----|---|---|--------------------------------------|--|--|---|------|
| 4.1 | Аймгийн ЗДТГ-ын “Хууль эрх зүйн” хэлтэс, ГХБХБГ, ГБХЗХГ-тай хамтран ажиллах | - | -Хамтран зохион байгуулсан ажлын тоо | 2021 онд аймгийн Аймгийн ЗДТГ-ын “Хууль эрх зүйн” хэлтэс болон ГБХЗХГ-тай хамтран “Иргэний андгай өргөх” болон “Гэрлэлтийн андгай өргөх” ажлыг 2 удаа зохион байгуулсан. | -Сумдын ЗДТГазартай тогтмол хамтран ажиллаж байгаа бөгөөд “Иргэний андгай өргөх ёслол”, “Гэрлэлтийн андгай өргөх ёслол”-ыг 23 сум, 1 тосгоны улсын бүртгэгч нар тогтмол зохион байгуул 364 хүүхдийг иргэний андгай өргүүлж, 57 гэр бүлд тангараг өргөх үйл ажиллагааг зохион байгуулсан.<br>- “Монгол улсын Иргэний үнэмлэх гардуулах ёслол”-ыг 2022 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Мөрөн суманд амжилттай зохион байгуулж, Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн сурлага хөдөлмөр, урлаг, спортоор тэргүүлсэн 30 хүүхэд иргэний үнэмлэхээ хүндэтгэлтэйгээр гардан авч, эх орон ард түмнийхээ өмнө тангараг өргөсөн.<br>-Мөсний баярын үйл ажиллагаанд ЗДТГ-тай хамтран оролцож, тус хэлтсийн зүгээс давхардсан тоогоор 300 гаруй иргэдэд халуун аарц чацарганаар үйлчилж, улсын бүртгэлийн таницуулах | -Тус хэлтэс нь 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн аймгийн Голомт банктай хамтран лавлагаа, шилжилт хөдөлгөөн, үл хөдлөх эд хөрөнгийн гэрээний бүртгэлийн үйлчилгээний хураамжийг 5 ширхэг пос машинаар хүлээн авч, иргэдэд үзүүлэх бүртгэлийн үйлчилгээг улам ойртуулсан. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газраас Гэрэгэ киоск 1 ширхэг, Гэрэгэ пос машин 3 ширхэгийг тус хэлтэст шийдвэрлэн өгж, улсын бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээний хураамжийг бусад аймгийн улсын бүртгэлийн хэлтсүүдээс анх удаа Гэрэгэ пос машин болох цахим төлбөрийн хэрэгслээр хүлээн авж байна.<br><br>-Аймгийн ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын хуралдаанд иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг ойртуулах улсын бүртгэлийн үйлчилгээний 2 киоск машин авах асуудлыг дэвшүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 53.600.000 төгрөгөөр 2 киоск машин шийдвэрлүүлсэн. Уг киоск машиныг 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн иргэд иргэний улсын бүртгэлийн 13 төрлийн лавлагааг үнэ төлбөргүй, тоон гарын үсгийг киоск машинаас авах боломж бүрдээд байна. Нэг киоск машиныг Шинэ | 100% |
|-----|---|---|--------------------------------------|--|--|---|------|

|  |  |  |  |   |   |  |
|--|--|--|--|---|---|--|
|  |  |  |  | <p>материалыг байршуулан, хэлтсийн үйл ажиллагааг сурталчлан ажиллалаа.</p> <p>-Төрийн албаны ерөнхий шалгалт орон даяар 4 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулагдаж тус хэлтэс аймгийн Төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран оролцогчдын хурууны хээний бүртгэлийг тулган ажилласан.</p> <p>-2022 оны 3 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд Ханх сумын ЗДТГ-тай хамтран “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулсан ба уг арга хэмжээнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэн ажилласан ба нийт 42 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 2 иргэнд газар өмчлөх эрхийн гэрчилгээ, 3 иргэнд үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг олгосон байна.</p> <p>-2022 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр ГХБХБГ-аас газрын харилцааны едрийг тохиолдуулан зохион байгуулсан “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгт оролцож иргэдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Уг нээлттэй хаалганы</p> | <p>Мөрөн худалдааны төвд байршуулж иргэдэд Улсын бүртгэлийн үйл ажиллагааг ойртуулан ажиллаж эхлээд байна.</p> <p>-“Монгол улсын Иргэний үнэмлэх гардуулах ёслол”-ыг 2022 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр 30 хүүхэд, мөн 2022 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр тус аймгийн 16 хүүхэд иргэний үнэмлэхээ хүндэтгэлтэйгээр гардан авч, эх орон ард түмнийхээ өмнө тангараг өргөсөн.</p> <p>-Хөвсгөл аймаг дахь Хүүхэд гэр бүл залуучууд, хөгжлийн газартай хамтран хэлтсийн 1 өрөөг гэр бүл залууст зориулан тохижуулахаар болсон бөгөөд өрөөний хэмжээг авч тохижуулах дизайн зураг төсвөө гаргасан байна.</p> <p>-Хөвсгөл Аймгийн цэргийн штабтай хамтран аймгийн хэмжээнд 2022 оны намрын ээлжит цэрэг татлагад хамрагдаж байгаа Алаг-Эрдэнэ, Хатгал, Тариалан, Тосонцэнгэл, Түнэл, Их-уул, Рашаант, Ханх, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган, Мөрөн сумдын засаг даргын тамгын газартай хамтран цэргийн насны бүх иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг амжилттай зохион байгуулан ажиллалаа.</p> <p>-Хууль зүй, дотоод хэргийн сайд, аймгийн Засаг дарга нарын 2022</p> |  |
|--|--|--|--|---|---|--|

|  |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|--|--|--|
|  |  |  |  | <p>өдөрлөгөөр нийт 31 иргэнд үйлчилсэн байна.</p> <p>-2022 оны 5 дугаар сарын 02-ны өдөр Монголын хуульчдын холбоо, Аймгийн ЗДТГ-ын санаачлан зохион байгуулсан “Хуульчийн поробоно өдөр -2022” иргэдэд хууль зүйн зөвлөгөө үнэ төлбөргүй өгөх өдөрлөгт оролцож иргэдийг мэдээ мэдээллээр ханган зөвлөгөө өгч оролцсон.</p> <p>-2022.05.03-ны өдөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн нээлт “ХӨДӨЛМӨРЧ ХӨВСГӨЛЧҮҮД” төрийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгт оролцон иргэдэд мэдээ мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>-2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр Тариалан суманд “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгт зохион байгуулж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь түргэн шуурхай хүргэн ажилласан ба нийт 51 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 1 иргэнд газар өмчлөх эрхийн гэрчилгээ, 7</p> | <p>онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан тус хэлтэст хамаарах 6 заалтыг хяналтандаа авч хэрэгжилтийг 100 хувь ханган, тайланг хугацаанд нь Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.</p> |  |
|--|--|--|--|--|--|--|

|  |  |  |  |   |  |  |
|--|--|--|--|---|--|--|
|  |  |  |  | <p>иргэнд үл хөдлөх эд хөрөгийн өмчлөх эрхийн гэрчилгээг олгосон байна. Мөн барьцааны гэрээ-4, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл-1, худалдах худалдан авах гэрээ-1-ийг тус тус бүртгэсэн ба хувийн хэрэг хаах материал 4-ийг хүлээн авч УБЕГ-ын ЭХЭУБГ-т хүргүүлэн УБЕГ-ын даргын тушаал гарсны дагуу хувийн хэрэг бүртгэлийг хаасан байна.</p> <p>-Төрийн өмчийн тооллого орон даяар хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Хөвсгөл аймгийн ЗДТГ-тай хамтран 23 сум 1 тосгоны сумдын ЗДТГ, ИТХурлын нийт албан хаагчдад сургалт зохион байгуулсан.</p> <p>-Аймгийн Төрийн өмчийн тооллогын комисст хэлтсийн дарга Б.Мөнгөнзул, хуулийн этгээдийн улсын бүртгэгч Н.Азжаргал нар гишүүнээр орж, АЗДТГ-тай хамтран ажиллаж байна.</p> |  |  |
|--|--|--|--|---|--|--|

**Зорилт 5. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.**

|     |   |   |   |   |  |  |  |      |
|-----|---|---|---|---|--|--|--|------|
| 5.1 | Хэлтсийн 2022 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх. | - | <p>-Сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулах;</p> <p>- Сургалтуудыг хуваарийн дагуу зохион байгуулах;</p> <p>- Төлөвлөгөөний явц, биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган танилцуулах, дүгнэх.</p> | Хэлтсийн сургалтын үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний биелэлт 100%-тай хэрэгжсэн. | <p>-Хэлтэст авч хэрэгжүүлэх 2022 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулж төлөвлөгөөний дагуу холбогдох сургалтанд хамрагдаж байгаа бөгөөд тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 20, Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан 13, Аймгийн ЗДТГ болон бусад байгууллагаас зохион байгуулсан 4 нийт 37 удаагийн сургалтад хэлтсийн бүх албан хаагчид болон хэлтсийн дарга, холбогдох албан хаагчид бүрэн хамрагдсан байна. Монгол хэл бичгийн сургалт болон Тагнуулын байгууллагын сургалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтыг хэлтсийн албан хаагчдад танхимаар зохион байгуулсан</p> <p>- Монгол улсын Ерөнхий сайдын санаачлагаар орон даяар хэрэгжсэн “Илүүдэлгүй жингүй-Эртэч Монгол” аянд хэлтсийн хамт олон нэгдэж 7 хоног бүрийн Лхагва гарагт идэвхитэй дасгал хөдөлгөөнд хамрагдан хэлтсийн нярав, бичиг хэргийн ажилтан Б.Маналжав илүүдэл</p> |  | <p>-Хэлтэст авч хэрэгжүүлэх 2022 оны сургалтын төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 13-ны боловсруулж, хэлтсийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу холбогдох сургалтанд хамрагдаж байгаа бөгөөд тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 29, Улсын бүртгэлийн ерөнхий газраас болон аймгийн ЗДТГ, бусад байгууллагаас зохион байгуулсан нийт 51 удаагийн сургалтад хэлтсийн бүх албан хаагчид болон хэлтсийн дарга, холбогдох албан хаагчид бүрэн хамрагдсан байна.</p> <p>-Тус хэлтэс нь улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаас ирүүлсэн шуурхай үүрэг даалгаврын биелэлтийн хүрээнд 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр хэлтсийн даргаар “Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдыг чадавхжуулах, хөрвөх чадвартай улсын бүртгэгч бэлтгэх” сургалтын төлөвлөгөөг батлуулан, 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрөөс тайлант хугацаанд хүртэл хуваарийн дагуу 15 сургалтыг амжилттай зохион байгуулсан байна.</p> <p>-Хэлтсийн сургалтын төлөвлөгөөнд тусгадсан сургалтуудыг амжилттай зохион байгуулж, хэлтсийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлж, хөрвөх чадвартай улсын бүртгэгчийг бэлтгэлээ.</p> | 100% |
|-----|---|---|---|---|--|--|--|------|

|     |   |   |   |  |   |  |  |
|-----|---|---|---|--|---|--|--|
|     |   |   |   |  | жингээсээ хасан эртэч Монгол иргэн болж “Батламж”, мөнгөн шагнал гардан авсан.  |  |  |
| 5.2 | Хэлтсийн албан хаагчдын нийгмийн баталгаа хангах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх. | - | - Төлөвлөгөөг батлуулах<br>-Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах | Албан хаагчдын нийгмийн баталгаа хангах ажлын хүрээнд шинээр хүүхэд мэндэлсэн 4 албан хаагчид мөнгөн урамшуулал олгосон. | --Хэлтсийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 5 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, 1-р улиралд албан хаагчдын хувцсыг жигдрүүлэх арга хэмжээний хүрээнд хувцасны үнэ, загвар, өнгөний судалгаа хийж байна.<br>-Төлөвлөгөөний дагуу хэлтсийн албан хаагчдыг 7 хоног бүр халуун аарц, чацаргана, аньсаар дархлааг нь дэмжин коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж |  | -Хэлтсийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 5 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдөр батлуулж хэрэгжилтийг 100% ханган ажиллалаа.<br><br>-2022 оны 1-р улиралд албан хаагчдын хувцсыг жигдрүүлэх арга хэмжээний хүрээнд хувцасны үнэ, загвар, өнгөний судалгаа хийж ажилласан боловч УБЕГын даргын 2022 оны 05 дугаар сарын 26-өдрийн 8/4645 албан бичгээр ирүүлсэн төсвийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд уг ажил хойшилсон байна. |

|  |  |  |  |   |   |      |
|--|--|--|--|---|---|------|
|  |  |  |  | <p>байна.</p> <p>-Тус хэлтсийн өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй Хатгал тосгоны улсын бүртгэгч М.Даваахүүгийн арг гэрт дэмжлэг үзүүлэх саналыг УБЕГ-т хүргүүлж, 5.000.000 төгрөгийн буцалтгүй тусламж олгогдсон байна.</p> <p>-Арбулаг, Цагаан-Уул, Цагааннуур, Чандмань-Өндөр, Их-Уул сумдын ЗДТГ-аас тус хэлтсийн улсын бүртгэгч нарыг УБ хотод эрүүл мэндийн багц үзлэгт хамруулж, хамтран ажиллах талаар ирүүлсэн албан бичгийн дагуу хэлтсийн зүгээс дээрх 5 сумын улсын бүртгэгч нарт 3 хоногийн чөлөөг олгон, үзлэг оношилгоонд хамруулсан.</p> <p>-Мөн Алаг-Эрдэнэ, Галт, Их-Уул, Улаан-Уул, Чандмань-Өндөр сумдын улсын бүртгэгч нарын гаргасан Глобал их сургуульд Эрх зүйч мэргэжлээр суралцан танимаар хилээллэх 14 хоногийн чөлөөний хүсэлтийг УБЕГ-т хүргүүлэн УБЕГ-н даргын тушаал гарж, чөлөөг олгосон хугцаанд бүртгэлийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн үргэлжлүүлсэн.</p> | <p>-Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн 2022.04.29-ний өдрийн 1/3742 тоот албан бичгийн дагуу Улаанбаатар хотод урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц үзлэгт хамрагдах албан хаагчдын судалгааг гарган хүргүүлсэн боловч төрийн албан хаагчийн нэгдсэн эмнэлгийн үзлэгийн цаг дууссантай холбогдуулан хойшилсон.</p> <p>-2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн санаачлагаар зохион байгуулсан төрийн албан хаагчдын эрүүл мэндийн оношлогооны ясны сийрэгжилтийн шинжилгээнд хэлтсийн 13 албан хаагч хамрагдаж, тохирох эмчилгээний зөвлөгөөг авсан.</p> <p>-Тус хэлтсийн үйлчилгээний заалны дуу чимээ багасгах, өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, акустик хавтангаар ханыг ашиглан бүтээлч ажил зохион байгуулж, хэлтсийн албан хаагчдын ажлын байрны орчин нөхцлийг сайжруулсан.</p> <p>-Тус хэлтсийн Арбулаг, Цагаан-Уул, Цагааннуур, Чандмань-Өндөр, Их-Уул сумдын ЗДТГ-аас тус хэлтсийн улсын бүртгэгч нарыг УБ хотод эрүүл мэндийн багц үзлэгт хамруулж, хамтран ажиллах талаар ирүүлсэн албан</p> | 100% |
|--|--|--|--|---|---|------|



|  |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|--|--|--|
|  |  |  |  | <p>-Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн 2022.04.29-ний өдрийн 1/3742 тоот албан бичгийн дагуу Улаанбаатар хотод урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц үзлэгт хамрагдах албан хаагчдын судалгааг гарган хүргүүлсэн.</p> <p>-Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээлэл технологийн ажилтан А.Лхагвасүрэнгийн охин болон Хан-Уул дүүргийн улсын бүртгэгчийн гэр бүлийн хүний эмчилгээний зардалд хандив өргөж, сайн үйлсийн аянд хамт олноороо нэгдсэн.</p> <p>-Хэлтсийн Эцэг эхийн зөвлөлийг хэлтсийн даргын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/01 тушаалаар шинэчлэн баталж үйл ажиллагааны төлөвлөгөө батлан ажиллаж байгаа бөгөөд олон улсын Эх үрсийн баярын өдрыг тохиолдуулан хэлтсийн 47 албан хаагчийн гэр бүлд болон хэлтсийн зүгээс дааж авсан 3 хүүхдэд тус бүрт нь 40.000 төгрөгний үнэ бүхий баярын бэлгийг гардуулан өгсөн.</p> | <p>бичгийн дагуу хэлтсийн зүгээс дээрх 5 сумын улсын бүртгэгч нарт 3 хоногийн чөлөөг олгон, үзлэг оношилгоонд хамруулсан.</p> <p>-Мөн Алаг-Эрдэнэ, Галт, Их-Уул, Улаан-Уул, Чандмань-Өндөр сумдын улсын бүртгэгч нарын гаргасан Глобал их сургуульд Эрх зүйч мэргэжлээр суралцан танхимаар хилээллэх 14 хоногийн чөлөөний хүсэлтийг УБЕГ-т хүргүүлэн УБЕГ-н даргын тушаал гарж, чөлөөг олгосон хугацаанд бүртгэлийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн үргэлжлүүлсэн. Мөн хэлтсийн даргын 45 чөлөөний хуудсаар албан хаагчдад чөлөө олгож ажилласан.</p> |  |
|--|--|--|--|--|--|--|

**6. Улсын бүртгэлийн ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан нэмэлтээр ажил зохион байгуулсан байна.**

|     |  |   |   |   |   |  |   |      |
|-----|--|---|---|---|---|--|---|------|
| 6.1 | Улсын бүртгэлийн байгууллагын харьяа нэгжүүдэд цахим төлбөрийн хэрэгсэл болох пос машины тоог нэмэгдүүлэх. | Төрийн болон төрийн бус байгууллагын тусламж, дэмжлэг | Пос машинаар үзүүлсэн үйлчилгээний тоо. | 2021 оны 11 дүгээр сарын байдлаар: Гэрэгэ киоск-198745, Е-баримт аппликейшнээр-54, нийт 198799 иргэн үйлчилгээ авсан байна. | Тус хэлтэс нь 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн Голомт банктай хамтран лавлагаа, шилжилт хөдөлгөөн, үл хөдлөх эд хөрөнгийн гэрээний бүртгэлийн үйлчилгээний хураамжийг 5 ширхэг пос машинаар хүлээн авч, иргэдэд үзүүлэх бүртгэлийн үйлчилгээг улам ойртуулсан. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газраас Гэрэгэ киоск 1 ширхэг, Гэрэгэ пос машин 3 ширхэгийг тус хэлтэст шийдвэрлэн өгж, улсын бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээний хураамжийг цахим төлбөрийн хэрэгслээр хүлээн авж байна. Тайлант хугацаанд Гэрэгэ киоск болон пос машинаар 1044 үйлчилгээний 9.799.665 төгрөг, Голомт банкны пос машинаар 5.796.100 төгрөгийн үйлчилгээний хураамжийг тус тус авсан байна |  | -Тус хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газраар Гэрэгэ киоск 1 ширхэг, Гэрэгэ пос машин 3 ширхэгийг шийдвэрлүүлэн авч, улсын бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээний хураамжийг бусад аймгийн улсын бүртгэлийн хэлтсүүдээс анх удаа Гэрэгэ пос машин болох цахим төлбөрийн хэрэгслээр хүлээн авч байна. Тайлант хугацаанд Гэрэгэ киоск болон пос машинаар 1639 үйлчилгээний 11.636.760 төгрөгийг хүлээн авсан байна. Гэрэгэ пос, болон киоск машиныг үйлчилгээндээ нэвтрүүлснээр иргэдийн банк орох цаг завьг хэмнэн, үйлчилгээг улам ойртуулсан. | 100% |
| 6.2 | Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх киоск   |   | -Киоск машин шийдвэрлүүлсэн байдал      | -   |   |  | -Аймгийн ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын хуралдаанд иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг ойртуулах улсын   | 100% |

|  |   |  |  |  |  |  |  |  |
|--|---|--|--|--|--|--|--|--|
|  | <p>машиныг шийдвэрлүүлж, үйлчилгээнд нэвтрүүлэх</p> |  | <p>-Киоск машинаар иргэдэд үзүүлсэн үйлчилгээний тоо</p> |  |  |  | <p>бүртгэлийн үйлчилгээний 2 киоск машин авах асуудлыг дэвшүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 53.600.000 төгрөгөөр 2 киоск машин шийдвэрлүүлсэн. Уг киоск машиныг 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн иргэд иргэний улсын бүртгэлийн 13 төрлийн лавлагааг үнэ төлбөргүй, тоон гарын үсгийг киоск машинаас авах боломж бүрдээд байна. Нэг киоск машиныг Шинэ Мөрөн худалдааны төвд байршуулж иргэдэд Улсын бүртгэлийн үйл ажиллагааг ойртуулан ажиллаж эхлээд байна.</p> <p>-Тус хугацаанд 238 иргэн лавлагаа авч, 51 иргэн тоон гарын үсгээ киоск машинаас авсан байна.</p> |  |
|--|---|--|--|--|--|--|--|--|

*Төлөвлөгөөг үнэлсэн:*

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга  
(албан тушаал)  
2022.06.10  
Тэмдэг

**Төсвийн шууд захирагч**

.....  
(гарын үсэг)

/Д.Дэлгэрсайхан/

*Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:*

Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газрын дарга  
(албан тушаал)  
2022.06.10  
Тэмдэг

**Нэгжийн дарга**

.....  
(гарын үсэг)

/Т.Гантөмөр/

*Тайлагнасан:*

Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга  
(албан тушаал)  
2022.06.10  
Тэмдэг

**Нэгжийн дарга**

.....  
(гарын үсэг)

/Б.Мөнгөнзул/